



ӨМНӨГОВЬ АЙМАГ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 05 сарын 21 өдөр

Дугаар А/29

Даланзадгад сум

Эрүүл мэндийн газрын дэргэдэх ахмадын
зөвлөл, ажиллах журмыг батлах тухай

Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7 дах заалт, Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 243 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Ахмадын сан байгуулан ажиллах журам”-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Эрүүл мэндийн газрын дэргэдэх ахмадын зөвлөлийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар, ахмадын зөвлөлийн ажиллах журмыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай

2. Батлагдсан журмыг 2025 оны 06 дугаар сарын 02-ний өдрөөс эхлэн мөрдүүлэхийг Удирдлага төлөвлөлт санхүүгийн хэлтсийн дарга (Б.Ганшагай), Нийгмийн эрүүл мэндийн төвийн дарга (Б. Амгалан) нарт тус тус үүрэг болгосугай.

3. Ахмадуудын дунд зохион байгуулах ажлын төлөвлөгөөг жил бүр гарган батлуулж, төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнаж ажиллахыг ахмадын зөвлөлийн дарга (Б.Мидэрсүрэн), ахмадын асуудал хариуцсан мэргэжилтэн (Б.Ганцэцэг) нарт тус тус үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шинжилгээ, үнэлгээ, мэдээллийн хэлтсийн дарга (Б.Цагаанцэнд)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.ЖАВЗАНДУЛАМ

462501185

2025 оны 05 дугаар сарын 21-ны өдрийн
А/29.....дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



АХМАДЫН ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Зөвлөлийн дарга:

Б.Мидэрсүрэн

(ахмад ажилтан)

Зөвлөлийн гишүүд:

Д.Сэлэнгэ

(ахмад ажилтан)

М.Цэндсүрэн

(ахмад ажилтан)

Эрүүл мэндийн газрын даргын
2025 оны 05 дугаар сарын 21-ны өдрийн
А/29 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН АХМАДЫН ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

НЭГ. Нийтлэг үндэслэл

Тус байгууллагад ажиллаж байгаад тэтгэвэрт гарсан, бүртгэлтэй ахмад настнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэх, одоо ажиллаж байгаа ажилтнуудын залгамж холбоог бэхжүүлэх зорилгоор байгууллагад ажиллах Ахмадын зөвлөл цаашид /зөвлөл/-ийн үйл ажиллагааг зохицуулахад энэ журмын зорилго оршино.

Ахмад настны яс үндэс, нийгмийн гарал, шашин шүтлэг, үзэл бодол, нас хүйс, мэргэжил, боловсрол, эрхэлж байсан ажил, хөдөлмөр зэргээр үл ялгаварлан ахмад настан бүрд тэгш үйлчлэх зарчим баримтална.

ХОЁР.Зохион байгуулалт

1. Зөвлөлийг Эрүүл мэндийн газрын даргын тушаалаар байгуулан ажиллуулна.
2. Зөвлөл нь ажлын төлөвлөгөө гарган хэрэгжүүлж, ажлаа хагас ба бүтэн жилээр байгууллагын удирдлага болон нийт ахмадуудад тайлагнана.
3. Зөвлөл нь ажлын шаардлага гарах бүрд хуралдаж, холбогдох шийдвэрүүдийг гаргана.
4. Зөвлөлийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, гишүүдийн үйл ажиллагаанд хяналт тавьж заавар зөвлөгөө, үүрэг даалгавар өгөх, зөвлөлийн хуралдааныг товлон зарлах, ахмадуудтай уулзалт, ярилцлага хийх ажлыг зөвлөлийн дарга хариуцна.

ГУРАВ. Үйл ажиллагаа, гүйцэтгэл

1. Ахмадын зөвлөл нь ахмадын асуудал хариуцсан бодлогын мэргэжилтэнтэй хамтарч байгууллагын ахмадын хүрээнд хийх ажлын нэгдсэн төлөвлөгөөг гаргаж, жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор Эрүүл мэндийн газрын даргаар батлуулан, нийт ахмадууддаа танилцуулах, арга хэмжээг зохион байгуулах
2. Зөвлөл нь ахмадуудаас тэтгэмж, тусламж, хөнгөлөлт хүссэн санал, гомдол, өгөгдлийг хүлээн авч судлан ахмадын сангийн журмын дагуу шийдвэр гаргуулахаар Эрүүл мэндийн газрын удирдлагад уламжлан шийдвэрлүүлнэ.
3. Зөвлөл нь Эрүүл мэндийн газартай хамтран “Хаврын тэргүүн сарын шинийн нэгэн-Цагаан сар, Олон улсын ахмадын өдрийг тохиолдуулан ахмад настнуудаа хүлээн авч хүндэтгэл үзүүлэх үйл ажиллагааг зохион байгуулна.
4. Ахмадуудын дунд зохион байгуулах /жилийн төлөвлөгөөнд тусгагдаагүй үлдсэн/ бусад үйл ажиллагааг ахмадын саналыг үндэслэн зохион байгуулна.
5. Зөвлөл нь ахмад залуу үеийн холбоог сайжруулах, ахмадуудаас суралцах, ажлын туршлага өвлүүлэх, халамжлан хүмүүжүүлэх, мөн ахмадаа асарч өргөх, хүндэтгэх ажлуудыг төлөвлөн хэрэгжүүлэх

6. Байгууллагын ахмадыг жилдээ 1 удаа эрүүл мэндийн эрт илрүүлэг үзлэгт хамруулах
7. Ахмадуудыг эрүүл байхад чиглэсэн идэвхтэй хөдөлгөөн, дасгалаар эрүүл мэндийг дэмжих арга хэмжээг зохиох
8. Эрүүл хооллолт, сэтгэл зүйн байдлыг оношлох зэрэг сургалт нөлөөллийн ажлуудыг үе шаттай зохион байгуулах, дэмжих
9. Байгууллагын үйл ажиллагааны түүхэн замналыг баяжуулах, ойн арга хэмжээнд залуу үеийнхнээ чиглүүлэхэд дэмжлэг болох

Дөрөв. Тайлан мэдээ гаргах, дүгнэх

1. Зөвлөл нь төлөвлөгөөний дагуу хийсэн ажлын тайланг хагас /06 дугаар сарын 15-25-ны хооронд/, бүтэн /12 дугаар сарын 15-25-ны хооронд/ жилээр байгууллагын ахмадуудад болон удирдлага, ажилчдад тайлагнаж ажиллах
2. Байгууллагын дотоод журамд тусгасан шилдэг ажилласан зөвлөлийг урамшуулах, алдаршуулах.